



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 512

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалт, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 268 дугаар тогтоолын 4.4, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 43,750,000.00 (дөчин гурван сая долоон зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга М.Мөнхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

D.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ
132001619

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны // дүгээр сарын // -ны өдрийн
5/8 дугаар тогтоолын хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИН

д/д	Автомашины нэр, зориулалт, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	ТӨБЗГ-ЫН 2020 оны 558 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Мицубуши пажеро, улсын дугаар 84-24 ДГО, арлын дугаар JMYLNV96W8J003827	2008/2008	43,750,000.00	1,500,000.00	750,000.00
Нийт дүн			43,750,000.00	1,500,000.00	750,000.00
			(Дөчин турван сая долоон зуун тавин мянга)		(Долоон зуун тавин мянга)